



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.03.25 № 02/УИ ЧАГ-САГ/2013/18/СТА-ТС

**ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГИЙН  
ДАРГА И.НАРАНТУЯА,  
НЯГТЛАН БОДОГЧ Г.ГАННЯМ  
НАРТ**

Зөрчил арилгуулах тухай

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Хүүхдийн төлөө сангийн 2012 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Олон нийтэд түшиглэсэн хүүхэд хамгааллын төв /ОНТХХТөв/-ийн ажилтнуудад 2011 оны үр дүнгийн нэмэгдэлд 13,261.1 мянган төгрөгийг олгосноос цалингийн зардал 2.7 сая төгрөгөөр хэтрэхэд нөлөөлснийг аудитаар илрүүлж зөвлөмж өгсөн байна. Гэвч ОНТХХТөвийн ажилтнуудтай байгуулсан гэрээний хугацаа 2011 онд дууссан байхад гэрээг сунгаагүй, хүчин төгөлдөр бус гэрээг үндэслэн 2012 оны үр дүнгийн нэмэгдэлд 8,785.2 мянган төгрөг олгож, улмаар цалингийн зардал 4.3 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Энэ нь “Төсвийн тухай хууль”-ийн 41.1, 41.2.2, 41.2.3 дугаар заалтыг зөрчиж төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сулруулахад хүргэсэн байна.

“Төрийн аудитын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 1-ийн 12 дугаар заалт, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1 дүгээр заалтыг үндэслэн дараах Албан шаардлага өгч байна. Үүнд:

Цаашид батлагдсан төсвийг хэтрүүлэн төсөвлөгдөөгүй үр дүнгийн урамшуулал олгодог асуудлыг таслан зогсоож, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллахыг Хүүхдийн төлөө сангийн дарга И.Нарантуяа, ерөнхий нягтлан бодогч Г.Ганням нарт шаардаж байна.

Энэхүү албан шаардлагын биелэлтийг 2013 оны 6 дугаар сарын 25-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР**



**Г.ЮРА**

070120